



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/524

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 72/01 дүгээр дүгнэлтийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, тоног төхөөрөмж (Өвөрхангай, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Хужирт сум) ЗГХЭГ/201902048 ажлын гүйцэтгэгч болон нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн багц-4 Сумдын Засаг даргын Тамгын газрын тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх багцыг 291468000 (хоёр зуун ерэн нэгэн сая дөрвөн зуун жаран найман) төгрөгөөр Цагаанбургалтай ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэх явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100924